



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/400

Чингис хот

Аймгийн хэмжээнд
цагийн хуваарь тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,2, 29.1.6-ийн "ж", Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүн амын тоо, төвлөрөл, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээ, аялал жуулчлал, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан үзэж худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг хоногийн 24 цагаар баталсугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт хоногийн 24 цагаар ажиллах болон цагийн хуваарийг шинэчлэн батлуулах худалдаа, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг нийт сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Хоногийн 24 цагаар худалдаа үйлчилгээ явуулахтай холбоотойгоор согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй баар, караокены цагийн хязгаарыг 11:00 цагаас 00:00 цаг хүртэл тогтоож бусад худалдаа, үйлчилгээний газрын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааны цагийн хязгаарт Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн нэгдсэн санд бүтгүүлсэн цагаар хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (Б.Батсайхан), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Сүнгээ), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231011032